ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Ховд аймгийн Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Аудитын код: ХОА-2022/123/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Аудитор: Д.Энхжаргал<br>Утас: 99434344<br>цахим хаяг: Enkhjargald@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........................................ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........................ 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........................................ 12

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........................................ 12

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........................................ 13

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 14

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ....... 14

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................ 15

**3.5.1 Төсвийн төлөвлөлт** ........................................ 15

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл** ........................................ 15

**3.5.3 Нэмэлт төсөв** ........................................ 16

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........................................ 16

**4.1 Ерөнхий зүйл** ........................................ 16

**4.2 Материаллаг байдал** ........................................ 16

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........................................ 16

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........................................ 17

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........................................ 17

**4.5 1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн** ..... 17

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................ 17

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........................................ 17

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........................................ 18


Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.24 № 02/94

танай ____________-ны №____________-т

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН 6 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАРСБОЛД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Энэ хичээлийн жилд Боловсрол, шинжлэх ухааны газраас "Тоглонгоо суралцъя" төсөл хэрэгжүүлэхэд зориулж 2,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

**Аудитын гол асуудал**

Тус сургууль нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан бол тайлант оны эхний 3 сард тогтмол зардлын санхүүжилтийг орон нутгаас, сүүлийн саруудын санхүүжилтийг улсын төсвөөс авсан онцлогтой байна.

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11.1 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус сургууль нь 960 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас 2022 онд 48 бүлэгт 1408 хүүхэдтэйгээр 69 багштай, 97 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 онд 4 зорилт 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, 87 хувьтай биелэлтийг тооцон Жаргалант сумын Засаг даргад хүргүүлжээ.

021020381

Тус сургууль нь 2022 онд 1-5 дугаар ангийн 20 бүлэгт нийт 93121 хүүхэд өдөр үдийн хоол арга хэмжээг хэрэгжүүлж 145.1 сая төгрөгийг зарцуулжээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **191,322,568.24** | **230,169,708.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 11,151,777.30 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 11,151,777.30 |
| **3121** | **Төгрөг** | - | 11,151,777.30 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 11,151,777.30 |
| **33** | **АВЛАГА** | 212,021.00 | 639,072.40 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 212,021.00 | - |
| **335** | **Бусад авлага** | - | 639,072.40 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 639,072.40 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 191,110,547.24 | 218,378,858.30 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,984,099.00 | 1,293,839.00 |
| 35130 | Эм боох материал | 2,984,099.00 | 1,293,839.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 188,126,448.24 | 217,085,019.30 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,032,250.00 | 2,032,250.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,741,277.00 | 3,219,277.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 183,352,921.24 | 211,833,492.30 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,945,547,544.60** | **1,970,688,534.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,945,547,544.60 | 1,970,688,534.20 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,639,658,294.48 | 1,664,913,534.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,722,942,059.34 | 1,722,942,059.34 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (249,740,334.04) | (335,988,078.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 276,044,391.53 | 409,517,037.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (237,732,612.32) | (262,539,527.24) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 168,876,726.73 | 175,806,726.73 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (103,616,067.77) | (115,688,635.25) |
| 39217 | Ном | 62,884,131.01 | 70,863,950.69 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 305,889,250.12 | 305,775,000.16 |
| 39301 | Програм хангамж | 857,000.00 | 857,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (742,749.88) | (856,999.84) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 305,775,000.00 | 305,775,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,136,870,112.84** | **2,200,858,242.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **53,937.82** | **10,564,148.64** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 53,937.82 | 10,564,148.64 |
| **413** | **Өглөг** | 53,937.82 | 10,564,148.64 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 53,937.82 | 9,901,427.64 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 662,721.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,136,816,175.02** | **2,190,294,093.56** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,136,816,175.02 | 2,190,294,093.56 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,788,204,349.14 | 1,788,204,349.14 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Омч: - төрийн | 305,775,000.00 | 305,775,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (439,837,470.07) | (386,359,551.53) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (439,837,470.07) | (439,837,470.07) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 53,477,918.54 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 788,449,295.95 | 788,449,295.95 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,136,870,112.84** | **2,200,858,242.20** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,934,541,191.65** | **2,431,764,137.14** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **54,353,838.32** | **80,905,037.14** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 54,353,838.32 | 80,905,037.14 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 600,000.00 | 3,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 3,000,000.00 |
| 120005 | Түрээсийн орлого | - | 4,159,500.00 |
| 120009 | Бусад орлого | - | 1,396,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,880,187,353.33** | **2,350,859,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,524,784,300.00 | 1,987,879,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,987,879,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,524,784,300.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 76,917,619.00 | 2,550,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 76,917,619.00 | 2,550,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 278,485,434.33 | 360,429,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 278,485,434.33 | 360,429,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,986,470,771.17** | **2,378,286,218.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,986,470,771.17** | **2,378,286,218.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,882,770,407.59 | 2,257,320,328.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,298,582,224.10 | 1,534,103,564.00 |
| 210101 | Үндсэн цалин | 910,443,954.10 | 1,051,659,699.00 |
| 210102 | Нэмэгдэл | 305,635,762.00 | 423,617,302.00 |
| 210104 | Урамшуулал | 82,502,508.00 | 58,826,563.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 168,507,994.90 | 191,770,146.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 117,094,779.96 | 131,077,102.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,013,095.25 | 15,420,835.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,410,476.19 | 12,313,148.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,544,513.04 | 2,994,057.44 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,445,130.46 | 29,965,002.26 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 276,758,534.33 | 308,258,975.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,692,180.20 | 7,316,278.30 |
| 210302 | Түлш, халаалт | 240,384,482.13 | 261,051,118.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,681,872.00 | 39,891,579.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,069,173.50 | 99,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,179,435.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 54,600.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 314,488.50 | 99,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 665,400.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,855,250.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 7,333,954.00 | 25,483,010.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,452,354.00 | 1,753,210.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 23,729,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,881,600.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,425,100.00 | 3,611,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,425,100.00 | 3,611,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 386,600.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 386,600.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,817,000.00 | 6,249,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,809,000.00 | 5,010,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,239,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 116,889,826.76 | 187,743,532.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 571,850.00 | 50,005,006.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,886,415.00 | 14,497,050.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 113,431,561.76 | 123,241,476.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 103,700,363.58 | 120,965,889.70 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 102,283,584.00 | 120,859,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,334,900.00 | 120,859,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 60,948,684.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,416,779.58 | 106,189.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,416,779.58 | 106,189.70 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(51,929,579.52)** | **53,477,918.54** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 13,496,217.31 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 13,496,217.31 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (13,496,217.31) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(65,425,796.83)** | **53,477,918.54** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,880,900,707.33** | **2,359,414,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **600,000.00** | **8,555,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 600,000.00 | 8,555,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 600,000.00 | 3,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 3,000,000.00 |
| 120005 | Түрээсийн орлого | - | 4,159,500.00 |
| 120009 | Бусад орлого | - | 1,396,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,880,300,707.33** | **2,350,859,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,524,784,300.00 | 1,987,879,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,987,879,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,524,784,300.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 76,917,619.00 | 2,550,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 76,917,619.00 | 2,550,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 278,485,434.33 | 360,429,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 278,485,434.33 | 360,429,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 113,354.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 113,354.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,880,900,707.33** | **2,348,262,822.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,880,900,707.33** | **2,348,262,822.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,777,086,989.75** | **2,230,937,933.30** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,280,395,910.92 | 1,525,168,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 800,235,912.00 | 1,064,953,136.40 |
| 210102 | Нэмэгдэл | 410,545,198.92 | 398,825,189.60 |
| 210104 | Урамшуулал | 69,614,800.00 | 61,389,774.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 186,880,589.00 | 190,646,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 131,984,104.00 | 129,639,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,623,971.00 | 15,161,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,831,914.00 | 12,291,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,585,500.00 | 3,050,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,855,100.00 | 30,503,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 276,758,534.33 | 307,985,310.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,633,000.00 | 8,526,810.30 |
| 210302 | Түлш, халаалт | 231,717,734.33 | 261,050,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 38,407,800.00 | 38,407,800.00 |
| 210304 | Байрны түрээс | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,192,777.50 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,625,900.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 172,600.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,281,899.50 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 586,800.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,158,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,367,578.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 2,587,500.00 | 27,870,817.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 705,900.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | - | 27,870,817.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,881,600.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,626,800.00 | 1,726,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,626,800.00 | 1,726,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 446,600.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 446,600.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,608,000.00 | 21,388,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,600,000.00 | 5,010,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 16,378,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,590,278.00 | 156,152,206.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600,000.00 | 131,602,046.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,990,278.00 | 24,550,160.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **103,813,717.58** | **117,324,889.40** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 102,396,938.00 | 117,218,699.70 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 113,354.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,334,900.00 | 117,218,699.70 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 60,948,684.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,416,779.58 | 106,189.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,416,779.58 | 106,189.70 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **11,151,777.30** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 11,151,777.30 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 11,151,777.30 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,788,204,349.14 | 788,449,295.95 | (439,837,470.07) | 2,136,816,175.02 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,788,204,349.14** | **788,449,295.95** | **(439,837,470.07)** | 2,136,816,175.02 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,788,204,349.14** | **788,449,295.95** | **(439,837,470.07)** | 2,136,816,175.02 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,788,204,349.14** | **788,449,295.95** | **(439,837,470.07)** | 2,136,816,175.02 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,788,204,349.14** | **788,449,295.95** | **(439,837,470.07)** | 2,136,816,175.02 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 53,477,918.54 | 53,477,918.54 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,788,204,349.14** | **788,449,295.95** | **(386,359,551.53)** | 2,190,294,093.56 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2328609667.00 | 2347411822.70 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2328609667.00 | 2347411822.70 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2172582967.00 | 2230086933.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1525168100.00 | 1525168100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1144721700.00 | 1064953136.40 |
| 210102 | Нэмэгдэл | 361152100.00 | 398825189.60 |
| 210104 | Урамшуулал | 19294300.00 | 61389774.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 163832200.00 | 190646100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 129639400.00 | 129639400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15161800.00 | 15161800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12291400.00 | 12291400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3050300.00 | 3050300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3689300.00 | 30503200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 308091467.00 | 307985310.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7149300.00 | 8526810.30 |
| 210302 | Түлш, халаалт | 261050667.00 | 261050700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 39891500.00 | 38407800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | - | 27,870,817.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 27,870,817.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,726,900.00 | 1,726,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,726,900.00 | 1,726,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,378,000.00 | 20,537,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 4,159,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,378,000.00 | 16,378,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 157,386,300.00 | 156,152,206.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 132,819,400.00 | 131,602,046.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,566,900.00 | 24,550,160.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 156,026,700.00 | 117,324,889.40 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 156,026,700.00 | 117,218,699.70 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 156,026,700.00 | 117,218,699.70 |
| **2133** | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 106,189.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 106,189.70 |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,682,701,767.00 | 2,358,563,600.00 |
| **131** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,322,272,167.00 | 1,990,429,500.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,322,272,167.00 | 1,987,879,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 2,550,000.00 |
| 131104 | Дээд шатны захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,550,000.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 360,429,600.00 | 360,429,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 360,429,600.00 | 360,429,600.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 7,704,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 7,704,500.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **11,151,777.30** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 97.00 | 97.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 67.00 | 67.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 29.00 | 29.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1,408.00 | 1,408.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1,408.00 | 1,408.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | | |
| 630002 | Хувийн ЕБС | 1,408.00 | 1,408.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **97.00** | **97.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 72.00 | 72.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 1.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 23.00 | 23.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **851,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **851,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 851,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 851,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 851,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Жаргалант сумын зургаадугаар сургууль нь 2022 оны хичээлийн жилийг "Хүүхэд бүрийн нийгэм, сэтгэлзүй, эрүүл мэнд, танин мэдэхүйн хөгжлийг тодорхойлж, бие даан сурах арга барилыг дэмжин, бүтээлч шинэлэг аргазүйгээр сурлагын хоцрогдлыг бууруулж, сургалтын чанар, багшийн хөгжилд ахиц гаргах " гэсэн зорилго тавин 3 чиглэлийн хүрээнд 10 зорилт дэвшүүлж 79 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллажээ.

Зургаадугаар сургууль нь 4 заах аргын нэгдэлд сургалт бусад үйл ажиллагаа явуулдаг ба байгалийн ухааны заах аргын нэгдэлд 28, нийгмийн ухааны заах аргын нэгдэлд 20, бага ангийн заах аргын нэгдэлд 20, захиргаа аж ахуйн заах аргын нэгдэл 28 нийт 97 багш ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус сургууль нь бага ангийн 20, дунд, ахлах ангийн 47 багштай. Зөвлөх багш 3, тэргүүлэх зэрэгтэй багш 46, заах аргач багш 18, зэрэггүй багш байхгүй, нийт багш нарын 88.6% нь мэргэжлийн зэрэгтэй, 53 багш бакалавр, 28 багш магистр зэрэгтэй, дипломын дээд 7 багш байна. Нийт багш нар 100% багшлах эрхтэй.

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшний багш 0, II түвшний багш 2, III түвшний багш 4, 4 дүгээр түвшний 4, бусад багш нар 5 түвшинд шалгагдсан ба нийт оноогоор 61.5% авч, аймгийн дундаж 69.9%, улсын дунджаас 72.5%-н амжилтыг үзүүллээ.

Жаргалант сумын зургаадугаар сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 144 сурагч элсэж, 48 бүлэгт 1408 сурагч суралцаж, анги дүүргэлтийн дундаж 29 ба бага анги буюу 1-5 дугаар ангийн 20 бүлэгт 681, дунд анги буюу 6-9 дүгээр ангийн 16 бүлэгт 482, ахлах анги буюу 10-12 дугаар ангийн 12 бүлэгт 245 сурагч суралцаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд Боловсролын тухай хуульд 3 удаа, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд 2 удаагийн өөрчлөлт оржээ.

Боловсролын байгууллагын багш ажилтанд үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмуудад өөрчлөлт орсон байна. 2022 онд боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, багшийн хөгжлийг дэмжих, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, тоног төхөөремжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах журмыг шинээр баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын зургаадугаар сургуулийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны А/25 дүгээр тушаалаар хагас жилийн, 2022 оны 12 дугаар сарын 14-ний А/70 дугаар тушаалаар жилийн эцсийн төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Байгууллагын даргын 2022 оны 09 дүгээр сарын 15-ний өдрийн А/24 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулагдаж 28 үзүүлэлтээр байгууллагын гадаад, дотоод орчинд тавигдах шаардлагын хүрээнд үнэлж, гарсан эрсдэлийг илрүүлэн гадаад орчныг өндөр эрсдэлтэй, дотоод орчин эрсдэл бага үнэлэгдсэн байна. Сургуулийн гадаад, дотоод орчинд хүүхдийг эрсдэлд ертехөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 19 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган захирлаар батлуулан ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын зургаадугаар сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын зургаадугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63.9 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 11,151,777.3 | 11,151,777.3 |
| Авлага | 212,021.0 | 639,072.4 | 427,051.4 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 191,110,547.2 | 218,378,858.3 | 27,268,311.1 |
| Үндсэн хөрөнгө | 1,945,547,544.6 | 1,970,688,534.2 | 25,140,989.6 |
| Нөөцийн бараа | - | - | - |
| **Нийт хөрөнгө** | **2,136,870,112.8** | **2,200,858,242.2** | **63,988,129.4** |
| Өр төлбөр | 53,937.8 | 10,564,148.6 | 10,510,210.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,136,816,175.0 | 2,190,294,093.6 | 53,477,918.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,136,870,112.8** | **2,200,858,242.2** | **63,988,129.4** |

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Жаргалант сумын зургаадугаар сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63.9 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн

хөрөнгийн данстай холбоотой бөгөөд балансын үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Тайлант онд 64.3 сая төгрөгийн бараа материал авч, 37.1 сая төгрөгийн материал зарцуулж үлдэгдэл 27.2 сая төгрөгөөр өссөн.
- ✓ Байгууллагын хөрөнгөөр 101.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 46.4 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авч тайлант хугацаанд 123.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсантай холбоотой 53.5 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,858.0 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 3.0 сая , орон нутгийн төсвөөс 360.4 сая  нийт зарлагыг 3,221.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1,987.9 сая, орон нутгийн төсвөөс 360.4, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8.5 сая, төслийн нэмэлт санхүүжилт 2.6 сая төгрөг нийт 2,359.4 сая төгрөг гүйцэтгэлээр санхүүжиж 2,348.2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 0.1 сая төгрөг татан төвлөрүүлж, 11.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,359.4 сая төгрөг 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал | 1,525,168.10 | 1,525,168.10 | 0.00 | 100 |
| 2 | АО-н нийгмийн даатгалын шимтгэл | 163,832.20 | 190,646.10 | -26,813.90 | 116.4 |
| 3 | Тогтмол зардал | 308,091.50 | 307,985.30 | 106.20 | 99.97 |
| 4 | Хоол хүнс | 0.00 | 27,870.80 | -27,870.80 | |
| 5 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,726.90 | 1,726.90 | 0.00 | 100.00 |
| 6 | Бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр | 16,378.00 | 21,388.50 | -5,010.50 | 130.6 |
| 7 | Бараа үйлчилгээний бусад зардал | 157,386.30 | 156,152.20 | 1,234.10 | 99.2 |
| 8 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 156,026.70 | 117,218.70 | 38,808.00 | 75.1 |
| 9 | Татан төвлөрүүлсэн | 0 | 106.2 | -106.20 | |
| | **ДҮН** | 2,328,609.70 | 2,348,262.80 | -19,653.10 | 100.8 |

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төслийн 0.8 сая төгрөг орж ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын зургаадугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Энхжаргал 2023 оны 02 дугаар сарын 10-ний өдрөөс 02 дугээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,378.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 35.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 28.5 сая төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

12 дугаар зүйлд заасан бусад хангамжтай холбоотой гар утасны зардалд 0.7 сая төгрөгийн зардал гарсан ба энэ нь 45 багш нарын дата хэрэглээнд Боловсрол шинжлэх ухааны сайдын баталсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах журмын дагуу зарцуулагдсан байна.

14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалтын хүрээнд 97.5 сая төгрөгийн таблет, зөөврийн компьютер, толгой компьютерын худалдан авалт хийсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван саяас дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй, байсныг аудитын явцад залруулан мэдээлүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 8.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

Сая төгрөгөөр

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 8.1 | 3 | 8.1 | 100.0 |
| **Нийт дүн** | **3** | **8.1** | **3** | **8.1** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор багш нарт олгосон зардлын зарцуулалтад хяналт тавих

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7.6 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 7.6 сая төгрөгийн алдааг залруулав.Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд 7.6 сая төгрөгийн хөрөнгийн дансны кодыг буруу сонгож гарз бүртгэн тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 7.6 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дугээр сарын 25-ны 19 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

Аудитаар нийт 5.4 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 заалт бүхий 5.4 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

### 5.1 Зөвлөмж

#### *5.1.1 Багш нарт олгосон зардлын талаарх асуудал*

***Илрүүлэлт:*** *Нэр бүхий 6 багшид сургалтын багийн дэмжлэг нэрээр 5.4 сая төгрөг бараа үйлчилгээний бусад зардлаас олгож зарцуулалтын тайлан, анхан шатны баримт дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй нийцэхгүй байна.*

***Өгсөн зөвлөмж:*** *Багш нарт олгосон 5.4 сая төгрөгийн зарцуулалтын тайланг анхан шатны баримтын хамт авч гүйцэтгэлд хяналт тавих*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | | | Дүн |
| Хөрөнгийн дансны код буруу сонгож гарз бүртгэсэн | 1.0 | 7,637.1 | - | - | | | 1.0 | 7,637.1 |
| Дүн | 1.0 | 7,637.1 | - | - | - | - | 1.0 | 7,637.1 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |
|---|---|---|---|---|---|---|

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр бүхий 5 багшид олгосон зардлын зарцуулалтын тайлан анхан шатны баримт дутуу | 1 | 5,441.5 | | | | | 1 | 5,441.5 | | | - | - |
| Дүн | 1 | 5,441.5 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 5,441.5 | | | - | - |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** **Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАН БИЧСЭН:**

**АУДИТОР:** **Д.ЭНХЖАРГАЛ**